ЗАВХАН АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

# САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Асгат сумын Ерөнхий боловролын сургуулийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

**Аудитын код:** ЗАА-2025/117/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: www.audit.mn

Улиастай сум

2025 он

Завхан аймаг дахь Төрийн аудитын газрын

дарга, тэргүүлэх аудитор: Д.Бат-Ундраа

Утас: 99993365

Цахим хаяг: Bat-Undraa@audit.gov.mn

Аудитын менежер: Х.Болдбаатар

Утас: 99105506

Цахим хаяг: Boldbaatarkh@audit.gov.mn

Хаан соёмбо аудит ХХК -ы гэрээт аудитор: Б.Цэрэндэжид

Утас: 99218108

Цахим хаяг: Tserendejid1109@gmail.com

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## АГУУЛГА


1. Хараат бус аудиторын дүгнэлт 3
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл 4
   2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан 4
   2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан 4
   2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан 5
   2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан 6
   2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан 7
3. Санхүүгийн тайлангийн тодруулга........8
   3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа 8
   3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин 10
   3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал 10
   3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлт 11
4. Аудитын тайлан........13
   4.1 Ерөнхий зүйл ........13
   4.2 Материаллаг байдал ........14
   4.3 Төрийн хэмнэлтийн хуулийн хэрэгжилт........14
   4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал ........14
   4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт ........15
   4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал ........16
5. Аудитын илрүүлэлт ........16
6. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл


**Товчилсон үгийн жагсаалт**

| | |
|---|---|
| УСНББОУС | Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт |
| АДБОУС | Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт |
| ТӨБЗГ | Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар |

## 1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ


**ЗАВХАН АЙМАГ ДАХЬ**
**ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**
81090 Улиастай, Завхан аймаг
Утас/Факс:7046-36-12
И-мэйл: zavkhan@audit.gov.mn


2025.02.21 № 186

танай ______ -ны № ______ -т

АСГАТ СУМЫН ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН СУРГУУЛИЙН ЗАХИРАЛ Д.ӨЛЗИЙЖАРГАЛ-Д

**Өөрчлөлтгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Асгат сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Асгат сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Асуудлыг онцолсон хэсэг**

Асгат сумын Ерөнхий боловсролын сургууль нь 2024 онд улсын төсвөөс 1,404,004.0 мянган төгрөгийн, орон нутгийн төсвөөс 234,842.5 мянган төгрөгийн санхүүжилттэй, 112,983.1 мянган төгрөгийн мөнгөн хөрөнгийн үлдэгдэлтэй ажилласан байна.

**Аудитын гол асуудал**

Асгат сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд дүгнэлт өгөх аудитаар үндсэн хөрөнгөнд бүртгэлтэй элэгдлээрээ анхны өртгөө бүрэн нөхсөн үлдэх өртөггүй 226 нэр төрлийн 287,694.4 мянган төгрөгийн хөрөнгийг дахин үнэлж, ашиглалтын хугацааг сунгаагүй, үдийн хоолны зардлаас зориулалт бусаар 2,500.0 мянган төгрөгийн торгууль төлсөн, 4,378.0 мянган төгрөгийн мөнгөн урамшууллыг давхардуулан олгосон байна.

**Бусад асуудлын хэсэг**

Асгат сумын Ерөнхий боловсролын сургууль нь төсвийн хөрөнгөөр 21,748.2 мянган төгрөгийн тоног төхөөрөмж, тавилга эд хогшил худалдан авч, Боловсролын ерөнхий газрын хөрөнгө оруулалтаар 13,016.6 мянган төгрөгийн тоног төхөөрөмж, Олон

Улсын энэрлийн байгууллагаас 17,401.7 сая төгрөгийн зөөврийн компьютер, 2,700.0 мянган төгрөгийн ном нийлүүлэгдсэнийг данс бүртгэлд тусгасан байна.

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР Д.БАТ-УНДРАА

## 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

### САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН

/ төгрөгөөр /

| Данс | Балансын зүйл | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|---|---|---|---|
| I | ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН | 54,673,832.21 | 204,547,889.90 |
| 31 | МӨНГӨН ХӨРӨНГӨ | 23,543,863.11 | 112,983,179.43 |
| 312 | Банкинд байгаа бэлэн мөнгө | 23,543,863.11 | 112,983,179.43 |
| 3121 | Төгрөг | 23,543,863.11 | 112,983,179.43 |
| 31211 | Төрийн сангийн харилцах | 23,543,863.11 | 112,983,179.43 |
| 33 | АВЛАГА | | 30,144,341.37 |
| 331 | Ажиллагчидтай холбогдсон авлага | | 30,144,341.37 |
| 35 | БАРАА МАТЕРИАЛ | 31,129,969.10 | 61,420,369.10 |
| 351 | Түүхий эд материал | 310,000.00 | 310,000.00 |
| 3511 | Тусгай зориулалттай материал | 310,000.00 | 310,000.00 |
| 354 | Хангамжийн материал | 30,819,969.10 | 61,110,369.10 |
| 3541 | Бичиг хэргийн материал | 1,708,952.00 | 4,426,952.00 |
| 3542 | Аж ахуйн материал | 4,643,939.20 | 4,591,939.20 |
| 3543 | Сэлбэг хэрэгсэл | 350,600.00 | 350,600.00 |
| 3544 | Түлш, шатах тослох материал | 9,225,846.29 | 9,225,846.29 |
| 3546 | Хүнсний материал | 10,865,226.61 | 17,953,626.61 |
| 3547 | Бусад хангамжийн материал | 4,025,405.00 | 24,561,405.00 |
| II | ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН | 685,850,415.59 | 784,671,038.52 |
| 39 | ҮНДСЭН ХӨРӨНГӨ | 685,850,415.59 | 784,671,038.52 |
| 392 | Биет хөрөнгө | 660,662,248.80 | 759,482,871.73 |
| 39201 | Барилга, байгууламж, орон сууц | 599,217,690.00 | 599,217,690.00 |
| 39202 | Хуримтлагдсан элэгдэл | -57,449,558.08 | -67,506,519.64 |
| 39203 | Авто-тээврийн хэрэгсэл | 14,000,000.00 | 14,000,000.00 |
| 39204 | Хуримтлагдсан элэгдэл | -14,000,000.00 | -14,000,000.00 |
| 39205 | Машин тоног төхөөрөмж (компьютер) | 144,578,402.33 | 260,029,872.33 |
| 39206 | Хуримтлагдсан элэгдэл | -66,779,871.91 | -74,145,375.33 |
| 39207 | Тавилга, аж ахуйн эд хогшил | 63,874,351.10 | 65,086,551.10 |
| 39208 | Хуримтлагдсан элэгдэл | -37,938,705.64 | -38,359,287.73 |
| 39214 | Бусад үндсэн хөрөнгө | 7,208,482.91 | 7,208,482.91 |
| 39215 | Хуримтлагдсан элэгдэл | -7,208,482.91 | -7,208,482.91 |
| 39217 | Ном | 15,159,941.00 | 15,159,941.00 |
| 393 | Биет бус хөрөнгө | 25,188,166.79 | 25,188,166.79 |
| 39301 | Програм хангамж | 1,820,000.00 | 1,820,000.00 |
| 39302 | Хуримтлагдсан элэгдэл | -1,865,833.21 | -1,865,833.21 |
| 39303 | Бусад биет бус хөрөнгө | 25,234,000.00 | 25,234,000.00 |
| III | НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II | 740,524,247.80 | 989,218,928.42 |
| IV | НИЙТ ӨР ТӨЛБӨР | | 78,428,200.00 |
| 41 | БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР | | 78,428,200.00 |
| 413 | Өглөг | | 78,428,200.00 |

| | | | |
|---|---|---|---|
| 4132 | Бараа үйлчилгээний зардлын өглөг | | 13,967,200.00 |
| 4136 | Бусад өглөг | | 64,461,000.00 |
| 41361 | Байгууллагад төлөх өглөг | | 64,461,000.00 |
| V | ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН | 740,524,247.80 | 910,790,728.42 |
| 51 | Засгийн газрын хувь оролцоо | 740,524,247.80 | 910,790,728.42 |
| 511 | Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан | 285,271,518.27 | 285,271,518.27 |
| 512 | Хуримтлагдсан үр дүн | -55,930,352.67 | 114,336,127.95 |
| 5121 | Өмнөх үеийн үр дүн | -55,930,352.67 | -55,930,352.67 |
| 5122 | Тайлант үеийн үр дүн | | 170,266,480.62 |
| 513 | Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | 511,183,082.20 | 511,183,082.20 |
| VI | ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V | 740,524,247.80 | 989,218,928.42 |

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

### САНХҮҮГИЙН ҮР ДҮНГИЙН ТАЙЛАН

/ төгрөгөөр /

| Данс | Үзүүлэлт | Өмнөх он | Тайлант он |
|---|---|---|---|
| I | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I) | 1,062,996,774.00 | 1,672,120,106.00 |
| 12 | ТАТВАРЫН БУС ОРЛОГО | 1,708,774.00 | 33,273,606.00 |
| 120 | Нийтлэг татварын бус орлого | 1,708,774.00 | 33,273,606.00 |
| 120004 | Төсөв байгууллагын өөрийн орлого | 621,300.00 | |
| 1200041 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 503,300.00 | |
| 1200042 | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 118,000.00 | |
| 120009 | Бусад орлого | | 119,136.00 |
| 120017 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө | 1,087,474.00 | 30,454,470.00 |
| 120018 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал | | 2,700,000.00 |
| 13 | ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО | 1,061,288,000.00 | 1,638,846,500.00 |
| 1310 | Улсын төвлөрсөн төсвөөс | 904,278,500.00 | 1,404,004,000.00 |
| 131001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 904,278,500.00 | 1,404,004,000.00 |
| 1320 | Орон нутгийн төсвөөс санхүүжих | 157,009,500.00 | 234,842,500.00 |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 157,009,500.00 | 234,842,500.00 |
| II | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН | 1,045,613,288.08 | 1,501,853,625.38 |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | 1,045,613,288.08 | 1,501,853,625.38 |
| 210 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 1,018,974,664.23 | 1,407,971,991.52 |
| 2101 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 702,895,017.02 | 1,017,039,359.48 |
| 210101 | Үндсэн цалин | 458,808,663.33 | 654,546,474.50 |
| 210102 | Нэмэгдэл | 189,713,586.69 | 300,081,394.98 |
| 210104 | Урамшуулал | 54,372,767.00 | 62,411,490.00 |
| 2102 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 82,917,791.88 | 131,553,314.43 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 54,915,691.88 | 84,540,684.64 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 6,959,300.00 | 10,144,775.35 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 5,606,900.00 | 14,569,387.65 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 1,373,800.00 | 4,454,237.94 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 14,062,100.00 | 17,844,228.85 |
| 2103 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 147,377,978.15 | 168,381,916.14 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 5,217,704.05 | 5,038,919.91 |
| 210302 | Түлш, халаалт | 140,780,474.10 | 162,302,896.23 |

| | | | |
|---|---|---|---|
| 210303 | Цэвэр, бохир ус | 1,379,800.00 | 1,040,100.00 |
| 2104 | Хангамж, бараа материалын зардал | 18,065,781.00 | 14,426,290.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 4,815,307.00 | 3,999,800.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 390,000.00 | 6,291,790.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 3,650,000.00 | |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 2,642,074.00 | |
| 210407 | Аж ахуйн материал худалдан авах зардал | 6,568,400.00 | 4,134,700.00 |
| 2105 | Нормативт зардал | 27,912,500.00 | 34,758,775.00 |
| 210502 | Хоол, хүнс | 27,912,500.00 | 34,758,775.00 |
| 2106 | Эд хогшил, урсгал засварын зардал | 8,199,000.00 | 3,998,300.00 |
| 210604 | Урсгал засвар | 8,199,000.00 | 3,998,300.00 |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 423,600.00 | 6,485,239.40 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 280,100.00 | |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 143,500.00 | 6,485,239.40 |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал | 31,182,996.18 | 31,328,797.07 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 9,002,300.00 | 6,115,750.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 51,000.00 | 7,370,000.00 |
| 210903 | Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол | 22,129,696.18 | 17,843,047.07 |
| 213 | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 26,638,623.85 | 93,881,633.86 |
| 2132 | Бусад урсгал шилжүүлэг | 26,590,590.00 | 31,419,350.00 |
| 213205 | Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал | 26,590,590.00 | 31,419,350.00 |
| 2133 | Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг | 48,033.85 | |
| 213303 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 48,033.85 | |
| 2134 | Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт | | 62,462,283.86 |
| 213403 | Төвлөрүүлэх шилжүүлэг | | 62,462,283.86 |
| III | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2) | 17,383,485.92 | 170,266,480.62 |
| V | НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4) | 17,383,485.92 | 170,266,480.62 |

## 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

### МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН

/ төгрөгөөр /

| Данс | Үзүүлэлт | Өмнөх он | Тайлант он |
|---|---|---|---|
| I | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1) | 1,061,909,300.00 | 1,638,965,636.00 |
| 12 | ТАТВАРЫН БУС ОРЛОГО | 621,300.00 | 119,136.00 |
| 120 | Нийтлэг татварын бус орлого | 621,300.00 | 119,136.00 |
| 120004 | Төсөв байгууллагын өөрийн орлого | 621,300.00 | |
| 1200041 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 503,300.00 | |
| 1200042 | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 118,000.00 | |
| 120009 | Бусад орлого | | 119,136.00 |
| 13 | ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО | 1,061,288,000.00 | 1,638,846,500.00 |
| 1310 | Улсын төвлөрсөн төсвөөс | 904,278,500.00 | 1,404,004,000.00 |
| 131001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 904,278,500.00 | 1,404,004,000.00 |
| 1311 | Нэмэлт санхүүжилтийн орлого | | |
| 1320 | Орон нутгийн төсвөөс санхүүжих | 157,009,500.00 | 234,842,500.00 |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 157,009,500.00 | 234,842,500.00 |
| II | НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2) | 1,031,160,140.90 | 1,527,778,119.68 |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | 1,031,160,140.90 | 1,527,778,119.68 |
| 210 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 1,004,415,487.05 | 1,433,886,485.82 |

| | | | |
|---|---|---|---|
| 2101 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 697,255,177.19 | 1,037,382,015.28 |
| 210101 | Үндсэн цалин | 453,168,824.24 | 667,396,200.46 |
| 210102 | Нэмэгдэл | 189,713,586.69 | 304,474,837.01 |
| 210104 | Урамшуулал | 54,372,766.26 | 65,510,977.81 |
| 2102 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 87,780,331.71 | 141,049,000.00 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 59,778,231.71 | 96,377,500.00 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 6,959,300.00 | 11,582,000.00 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 5,606,900.00 | 5,644,800.00 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 1,373,800.00 | 5,862,600.00 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 14,062,100.00 | 21,582,100.00 |
| 2103 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 147,004,666.15 | 168,381,916.14 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 5,445,804.05 | 5,038,919.91 |
| 210302 | Түлш, халаалт | 140,290,062.10 | 162,302,896.23 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 1,268,800.00 | 1,040,100.00 |
| 2104 | Хангамж, бараа материалын зардал | 5,621,000.00 | 6,291,790.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 5,621,000.00 | 6,291,790.00 |
| 2105 | Нормативт зардал | 33,983,200.00 | 38,101,175.00 |
| 210502 | Хоол, хүнс | 33,983,200.00 | 38,101,175.00 |
| 2106 | Эд хогшил, урсгал засварын зардал | 10,180,000.00 | 3,998,300.00 |
| 210604 | Урсгал засвар | 10,180,000.00 | 3,998,300.00 |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 4,705,600.00 | 16,797,039.40 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 280,100.00 | |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 4,425,500.00 | 16,797,039.40 |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал | 17,885,512.00 | 21,885,250.00 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 11,246,612.00 | 14,501,250.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 6,638,900.00 | 7,384,000.00 |
| 213 | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 26,744,653.85 | 93,891,633.86 |
| 2132 | Бусад урсгал шилжүүлэг | 26,696,620.00 | 31,429,350.00 |
| 213205 | Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал | 26,696,620.00 | 31,429,350.00 |
| 2133 | Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг | 48,033.85 | |
| 213303 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 48,033.85 | |
| 2134 | Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт | | 62,462,283.86 |
| 213403 | Төвлөрүүлэх шилжүүлэг | | 62,462,283.86 |
| III | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2) | 30,749,159.10 | 111,187,516.32 |
| V | ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5) | 20,955,000.00 | 21,748,200.00 |
| | Дотоод эх үүсвэрээр | 20,955,000.00 | 21,748,200.00 |
| 222001 | Тоног төхөөрөмж | | 20,536,000.00 |
| 223001 | Бусад хөрөнгө | 20,955,000.00 | 1,212,200.00 |
| VI | ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5) | -20,955,000.00 | -21,748,200.00 |
| VIII | НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7) | 9,794,159.10 | 89,439,316.32 |
| 31 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | | 23,543,863.11 |
| 31 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | | 112,983,179.43 |

## 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

### ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН

/ төгрөгөөр /

| Д/Д | Үзүүлэлт | Засгийн газрын сан | Дахин үнэлгээний нөөц | Хуримтлагдсан үр дүн | ЗГ-н хувь оролцооны дүн |
|---|---|---|---|---|---|
| 1 | 20... оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл | 285,271,518.27 | 511,183,082.20 | -55,930,352.67 | 740,524,247.80 |
| 7 | Тайлант үеийн үр дүн | | | 151,574,450.06 | 151,574,450.06 |
| 10 | 20... оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл | 285,271,518.27 | 511,183,082.20 | -55,930,352.67 | 740,524,247.80 |
| 11 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | | | | |
| 12 | Дахин илэрхийлсэн үлдэгдэл | | | | |
| 13 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт | | | | |
| 14 | Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт | | | | |
| 15 | Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз | | | | |
| 16 | Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү | | | | |
| 17 | Тайлант үеийн үр дүн | | | 170,266,480.62 | 170,266,480.62 |
| 18 | ................ | | | | |
| 19 | 20... оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл | 285,271,518.27 | 511,183,082.20 | 114,336,127.95 | 910,790,728.42 |

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

### ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

/ төгрөгөөр /

| Д/Д | Үзүүлэлт | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | Зөрүү дүн | Харьцуулалт |
|---|---|---|---|---|---|
| | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | | | | |
| 2 | НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН | 1,681,130,500.00 | 1,314,683,819.68 | 366,446,680.32 | 78.2 |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | 1,681,130,500.00 | 1,292,935,619.68 | 388,194,880.32 | 76.91 |
| 210 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 1,654,691,300.00 | 1,261,506,269.68 | 393,185,030.32 | 76.24 |
| 2101 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 1,112,413,000.00 | 1,037,382,015.28 | 75,030,984.72 | 93.26 |
| 210101 | Үндсэн цалин | 750,393,200.00 | 667,396,200.46 | 82,996,999.54 | 88.94 |
| 210102 | Нэмэгдэл | 343,567,300.00 | 304,474,837.01 | 39,092,462.99 | 88.62 |
| 210104 | Урамшуулал | 18,452,500.00 | 65,510,977.81 | -47,058,477.81 | 355.02 |
| 2102 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 148,234,400.00 | 141,049,000.00 | 7,185,400.00 | 95.15 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 94,555,000.00 | 96,377,500.00 | -1,822,500.00 | 101.93 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 20,306,900.00 | 11,582,000.00 | 8,724,900.00 | 57.03 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 5,562,100.00 | 5,644,800.00 | -82,700.00 | 101.49 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 5,562,100.00 | 5,862,600.00 | -300,500.00 | 105.4 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 22,248,300.00 | 21,582,100.00 | 666,200.00 | 97.01 |
| 2103 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 298,723,700.00 | | 298,723,700.00 | |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 9,181,200.00 | | 9,181,200.00 | |
| 210302 | Түлш, халаалт | 288,390,000.00 | | 288,390,000.00 | |
| 210303 | Цэвэр, бохир ус | 1,152,500.00 | | 1,152,500.00 | |
| 2104 | Хангамж, бараа материалын зардал | | 6,291,790.00 | -6,291,790.00 | |
| 210402 | Тээвэр, шатахуун | | 6,291,790.00 | -6,291,790.00 | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 2105 | Нормативт зардал | 23,611,700.00 | 38,101,175.00 | -14,489,475.00 | 161.37 |
| 210502 | Хоол, хүнс | 23,611,700.00 | 38,101,175.00 | -14,489,475.00 | 161.37 |
| 2106 | Эд хогшил, урсгал засварын зардал | 4,000,000.00 | | 4,000,000.00 | |
| 210604 | Урсгал засвар | 4,000,000.00 | | 4,000,000.00 | |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 13,172,000.00 | 16,797,039.40 | -3,625,039.40 | 127.52 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 13,172,000.00 | 16,797,039.40 | -3,625,039.40 | 127.52 |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал | 54,536,500.00 | 21,885,250.00 | 32,651,250.00 | 40.13 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 47,159,500.00 | 14,501,250.00 | 32,658,250.00 | 30.75 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 7,377,000.00 | 7,384,000.00 | -7,000.00 | 100.09 |
| 213 | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 26,439,200.00 | 31,429,350.00 | -4,990,150.00 | 118.87 |
| 2132 | Бусад урсгал шилжүүлэг | 26,439,200.00 | 31,429,350.00 | -4,990,150.00 | 118.87 |
| 213205 | Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал | 26,439,200.00 | 31,429,350.00 | -4,990,150.00 | 118.87 |
| 22 | ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ | | 21,748,200.00 | -21,748,200.00 | |
| | Дотоод эх үүсвэрээр | | 21,748,200.00 | -21,748,200.00 | |
| 222001 | Тоног төхөөрөмж | | 20,536,000.00 | -20,536,000.00 | |
| 223001 | Бусад хөрөнгө | | 1,212,200.00 | -1,212,200.00 | |
| 1 | ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР | | 1,404,123,136.00 | -1,404,123,136.00 | |
| 131 | УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ | | 1,404,004,000.00 | -1,404,004,000.00 | |
| 131001 | Улсын төсвөөс санхүүжих | | 1,404,004,000.00 | -1,404,004,000.00 | |
| | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | | 23,543,863.11 | -23,543,863.11 | |
| | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | | 112,983,179.43 | -112,983,179.43 | |

**2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан**

Байхгүй

## 3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

### 3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

**Асгат сумын Ерөнхий боловролын сургуулийн *үйл ажиллагааны чиглэл:***

- *Бага, суурь, бүрэн дунд боловсрол эзэмшүүлэх*

**Асгат сумын Ерөнхий боловролын сургуулийн *зорилго*:** Сурагчдын бие даан бүтээлчээр унших, ярих чадварыг дэмжин зөв харилцаа хандлагатай, тусч, энэрэнгүй, эрүүл чийрэг, эх оронч үзэлтэй иргэн төлөвшүүлэхэд оршино.

### 3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

*Асгат сумын Ерөнхий боловролын сургуулийн үйл ажиллагаанд мөрддөг хууль:*

1. Төрийн албаны тухай хууль
2. Төсвийн тухай хууль
3. Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
4. Нийгмийн даатгалын ерөнхий хууль
5. Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
6. Хувь хүний орлогын албан татварын тухай хууль

7. СӨБ-н тухай хууль
8. Хөдөлмөрийн тухай хууль
9. Боловсролын ерөнхий хууль
10. Төрийн хэмнэлтийн тухай хууль
11. Шилэн дансны тухай хууль
12. Тендерийн тухай хууль

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

**Байгууллагын дотоод хяналтын талаар:** Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна гэж үзлээ. Дотоод хяналтын багийг байгуулж, төлөвлөгөө боловсруулан ажиллаж байна. Мөн Санхүүгийн өдөр тутмын ажил гүйлгээнд Хүүхдийн цэцэрлэгийн эрхлэгч, санхүүгийн албаны дарга, төсөв, төрийн сангийн мэргэжилтэн нар хяналтыг хийж байна.

Дотоод хяналтын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

### 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Асгат сумын Ерөнхий боловролын сургуулийн 2024 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэж, Төсвийн тухай хуулийн 54 дүгээр зүйлийн 54.4, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 8 дугаар зүйлд заасан иж бүрдлийн дагуу бэлтгэж толилуулсан байна.

Төсвийн гүйцэтгэлийн тайланг мөнгөн сууриар бэлтгэж, Төсвийн тухай хуулийн 54.5 дахь заалтын дагуу иж бүрэн гаргаж ирүүлсэн.

### 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд:

Асгат сумын Ерөнхий боловролын сургуулийн 2024 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2025 оны А/3 дугаар тушаалаар баталсан "Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар"-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгө өмнөх оноос 248,694.7 мянган төгрөгөөр буюу 1.33 хувиар өссөн байна.

***Хүснэгт 1.*** *Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт*

*/мянган төгрөгөөр/*

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өөрчлөлт |
|---|---|---|---|
| Б | 1 | 2 | 3=2-1 |
| Авлага | 0 | 30,144.3 | 30,144.3 |
| Бараа материал | 31,129.9 | 61,420.3 | 30,290.4 |
| Үндсэн хөрөнгө | 658,850.4 | 784,671.0 | 125,820.6 |
| **Нийт хөрөнгө** | **740,524.2** | **989,218.9** | **248,694.7** |
| Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/ | 740,524.2 | 910,790.7 | 170,266.5 |
| **Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн** | **740,524.2** | **989,218.9** | **248,694.7** |

Санхүүгийн тайлангийн тодруулгыг мөнгөн хөрөнгө, үндсэн хөрөнгө, авлага, бараа материал, өр төлбөр гэсэн данс бүрээр холбогдох журам, зааврын дагуу бэлтгэсэн байна.

**Тайланд онд:**

Авлагын эхний үлдэгдэл байхгүй , тайлант онд 30,144.3 мянган төгрөгийн авлага нэмэгдэж, эцсийн үлдэгдэл 30,144.3 мянган төгрөг болсон байна.

Бараа материалын эхний үлдэгдэл 31,129.9 мянган төгрөг, төсвийн хөрөнгөөр 116,546.4 мянган төгрөгийн бараа материал нэмэгдэж, 86,256.0 мянган төгрөгийн бараа материал зарцуулж, эцсийн үлдэгдэл 61,420.3 мянган төгрөг болж, өмнөх оноос 30,290.4 мянган төгрөгөөр өссөн байна.

Үндсэн хөрөнгийн хувьд төсвийн хөрөнгөөр 86,209.2 мянган төгрөгийн хөрөнгө худалдан авч , хөрөнгө оруулалтаар 30,454.4 мянган төгрөгийн хөрөнгө үнэ төлбөргүйгээр нэмэгдэж, жилийн эцэст 987,756.5 мянган төгрөгийн хөрөнгийн үлдэгдэлтэй байна. Тайлант оны элэгдлийн зардалд 17,843.0 мянган төгрөгийг тооцож бүртгэсэн байна.

### 3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

### 3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2023 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс 1,672,120.5 мянган төгрөг, нийт зарлагыг 1,672,120.5 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна. Цалин, ажил олгогчоос төлөх нийгмийн даатгалын шимтгэл, тодотголоор нэмж баталсан байна.

### 3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 12 арга хэмжээг санхүүжүүлэхээр улсын төсвөөс 1,404,004.0 мянган төгрөг, орон нутгийн төсвөөс 234,842.5 мянган төгрөгийн санхүүжилт авсан байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 1,527,778.1 мянган төгрөг буюу 93.2 хувьтай байна. Энэ нь цалин, ндш, хоол хүнс, бусад бараа материалын зардлыг тус тус хэмнэсэнтэй холбоотой байна.

***Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл***

*/мянган төгрөгөөр/*

| Хөтөлбөр арга хэмжээ | Үзүүлэлт | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | Зөрүү | Биелэлт |
|---|---|---|---|---|---|
| **Улсын төсвөөс санхүүжих** | | | | | |
| **71802** | **Ерөнхий боловсрол** | | | | |
| 80226 | Байр ашиглалтын үйлчилгээ | 1,845.30 | 1,769.50 | 75.80 | 95.9% |
| 80233 | Хүүхэд хамгаалал | 1,960.60 | 1,920.50 | 40.10 | 97.9% |
| 81605 | Эрүүл мэндийг дэмжих | 1,839.4 | 1,839.0 | 0.40 | 100% |
| 81806 | Дотуур байрны үйлчилгээ | 194,189.2 | 167,309.1 | 26,880.1 | 86.2% |
| 81816 | Хүүхдэд ээлтэй сургалтын орчин | 21,836.5 | 21,748.2 | 2,600.60 | 93% |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 81823 | Боловсролын байгууллагын багш ажилтны мэргэжил дээшлүүлэх | 5,388.7 | 978.5 | 4,410.2 | 18.1% |
| 81827 | Бичиг үсгийн боловсрол | 12,480.6 | 10,903.0 | 1,577.6 | 87.3% |
| 81834 | Боловсролын стандарт сургалтын орчин | 1,103,436.8 | 903,660.8 | 199,776.0 | 81.8% |
| 81835 | Сургалтын хэвийн үйл ажиллагаа | 30,542.0 | 18,344.1 | 12,197.9 | 60.06% |
| 80312 | Сургалт семинар | 1,355.2 | 1,355.1 | 0.10 | 100% |
| 81801 | Үдийн цай хөтөлбөр | 31,429.7 | 31,429.3 | 0.35 | 99.9% |
| 81848 | Сурах бичгийн түрээс | 118.0 | 118.0 | 0.00 | 100% |
| 81875 | Сургуулийн нэмэлт хөтөлбөр хэрэгжүүлэх | 2,439.6 | 2,439.5 | 0.50 | 100% |
| **НИЙТ** | | **1,408,861.60** | **1,163,814.60** | **247,559.65** | **83%** |
| **Орон нутгийн төсвөөс санхүүжих** | | | | | |
| 80109 | ТЗШ-ийн байгууллагын тогтмол зардал | 234,842.5 | 234,842.5 | 0.00 | 100% |

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

### 3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т "нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна" гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт санхүүжилтээр 234,842.5 мянган төгрөгийн санхүүжилт авч байна. Гүйцэтгэлээр 234,842.5 мянган төгрөгийг гэрэл цахилгаан, халаалт цэвэр ус, урсгал засварын зардалд тус тус зарцуулсан байна.

### 3.5.4 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн

Тайлант хугацаанд төсөл, хөтөлбөр хэрэгжүүлээгүй байна.

### 3.5.5 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэлийн талаар

Худалдан авалтыг шууд худалдан авалтаар зохион байгуулсан.
Тайлант оны худалдан авах ажиллагаа нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуульд нийцсэн, Засгийн газрын 2021 оны 124 дүгээр тогтоолоор баталсан босго үнийг баримталсан байна. Худалдан авах ажиллагаатай холбоотой зөрчилтэй зүйл илрээгүй болно.

## 4. АУДИТЫН ТАЙЛАН

### 4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д "Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана." гэж заасны дагуу Асгат сумын Хүүхдийн цэцэрлэгийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг "Хаан соёмбо аудит" ХХК-ийн гэрээт аудитор Б.Цэрэндэжид гүйцэтгэж Завхан аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор Ц.Оюунсувд анхан шатны хяналт хийж, чанарын хяналтыг аудитын менежер Х.Болдбаатар дарга, тэргүүлэх аудитор Д.Бат-Ундраа нар хэрэгжүүлсэн.

Асгат сумын Ерөнхий боловролын сургуулийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Завхан аймаг дахь Төрийн аудитын газарт 2025 оны 01 дүгээр сарын 23-ны өдрийн 02 тоот албан бичгээр ирүүлсэн байна.

### 4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг "Дунд" гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2024 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт орлогыг 1,501,853.6 мянган төгрөгөөс 2 хувиар буюу 30,037,1 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 80 хувиар буюу 24,029,6 мянган төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг дахин хянаж, шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

### 4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хуулийн шалгуур үзүүлэлтээс тухайн шалгагдагч байгууллагатай хамааралтай 31 заалтыг сонгож, горим сорил хэрэгжүүлсэн бөгөөд алдаа, зөрчил илрээгүй байна.

### 4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

Байгууллагын 2024 оны санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийн нийцлийн асуудлыг авч үзсэн бөгөөд аудитын санал дүгнэлтэд хамруулан үзээгүй болно.

#### 4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан "Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам"-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан 6 төрлийн мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгалаа.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай хууль, тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн гэж дүгнэлээ.

### 4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

#### 4.5.1 Завсрын аудитын талаар

Асгат сумын Ерөнхий боловролын сургуулийн 2024 оны санхүүгийн тайланд завсрын аудит хийгдээгүй болно..

#### 4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар 7,631.3 мянган төгрөгийн зөрчилд 2 заалт зөвлөмж, 1 төлбөрийн акт өгөгдсөнийг хэрэгжүүлэн ажилласан байна.

*Хүснэгт 4:* Зөвлөмжийн хэрэгжилт 100% биелүүлсэн

*/мянган төгрөгөөр/*

| Үзүүлэлт | Өмнөх аудитын үзүүлэлт | | Биелэлт | | |
|---|---|---|---|---|---|
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Хувь |
| Зөвлөмж | 2 | 4,983.5 | 2 | 4,983.5 | 100% |
| Акт | 1 | 2,631.7 | 1 | 2,631.7 | 100% |
| **Нийт дүн** | **3** | **7,631.3** | **3** | **7,631.3** | **100%** |

### 4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Хүүхдийн хоолны нормативыг мөрдөж ажиллах, амархан муудаж, чанар байдал нь алдагдах хүнсний бүтээгдэхүүнийг нөөцөлж, удаан хугацаагаар хадгалахгүй байх, эд хариуцагчийн гаргаж байгаа бараа материалын тайланг сар бүр хянаж, үлдэгдлийг баталгаажуулж байх, Үндсэн хөрөнгө, бараа материалын тооллогыг хийж тухайн үед тооцоо бодож, үлдэгдлийг тулган баталгаажуулж байх

## 5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 6,078.1 мянган төгрөгийн алдаа илэрч, 6,078.1 мянган төгрөгийн төлбөрийн акт тогтоолоо.

***Залруулсан алдаа:***

Байхгүй

**Шийдвэрлэсэн байдал:** Байхгүй

### 5.1 Төлбөрийн акт:

- ***Илэрсэн алдаа:*** Албан хаагчдад үр дүнгийн урамшуулал 4,378.1 мянган төгрөгийн үр дүнгийн урамшууллыг илүү тооцож олгосон байна.
- **Шийдвэрлэсэн байдал:** Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", 16 дугаар зүйлийн 16.5.5 "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах", Засгийн газрын 2019 оны 5 дугаар тогтоолын 3 дугаар хавсралтаар батлагдсан "Төрийн албан хаагчид мөнгөн урамшуулал олгох журам"-ын 2.2-д "Төрийн албан хаагчид улирлын ажлын үр дүнгээр олгох мөнгөн урамшууллын дээд хэмжээ нь албан хаагчийн албан тушаалын сарын үндсэн цалингийн 40 хувиас хэтрэхгүй байна", 2.5-д "Энэ журмын 2.4-т зааснаас бусад төрийн албан хаагчид үр дүнгийн мөнгөн урамшууллыг хөдөлмөрийн гэрээнд заасан ажил үүргийн биелэлт, ажлын гүйцэтгэлийн үр дүнг үндэслэн олгоно" гэж заасныг тус тус зөрчсөнд 6,782.9 мянган төгрөгийн акт тогтоов.
- Үдийн хоолны зардлаас зориулалт бусаар 2,5000.0 мянган төгрөгийн торгууль төлсөн байна.
- Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", 16 дугаар зүйлийн 16.5.5 "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах", Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.2.батлагдсан төсвийн хүрээнд зарлага гаргах; Сангийн сайдын 2021 оны 190

дугээр тушаалаар батлагдсан "Зардлын эдийн засгийн ангилал ашиглах заавар"ыг, батлагдсан төсвийн дагуу эдийн засгийн ангилалаар зардал гаргах, хууль, журмыг мөрдөж ажиллах, хяналтыг хэрэгжүүлэх гэж заасныг тус тус зөрчсөнд 1,700.0 мянган төгрөгийн акт тогтоов.

**5.2 Албан шаардлага: өгөгдөөгүй**

**5.3 Зөвлөмж**

***Илэрсэн алдаа:*** Үндсэн хөрөнгийн дансанд бүртгэлтэй 226 нэр төрлийн 1696 ширхэг 287,694.4 мянган төгрөгийн хөрөнгө элэгдээрээ анхны өртгөө нөхсөн үлдэгдэл өртөггүй хөрөнгө бүртгэлтэй байна. . Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйл 5.1.4-д "үнэн зөв байх", 20 дугаар зүйлийн 20.2.3-т "холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах", ТӨБЗГ-ын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан "Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам"-ын 7.1-д "Төрийн өмчит хуулийн этгээд нь эзэмшилдээ байгаа илүүдэл хөрөнгө болон элэгдэл хорогдлын шимтгэлээр анхны үнийг нөхсөн, түүнчлэн нөхөөгүй боловч гэмтэж засаж сэлбээд өөр зориулалтаар ашиглаж болох эд хөрөнгийн ашиглалтын хугацаа болон үнийг шинэчлэн тогтоох саналыг бэлтгэн Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт ирүүлж шийдвэрлүүлнэ" гэж заасантай нийцэхгүй, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

***Өгсөн зөвлөмж:*** Дахин үнэлгээ хийх шалгуур хангасан хөрөнгөнд үнэлгээ хийж бүртгэлд тусгах, цаашид ашиглах боломжгүй хөрөнгүүдийг холбогдох газрын зөвшөөрлийн дагуу данснаас хасах арга хэмжээ авч, үндсэн хөрөнгийн бүртгэлийг цэгцлэх;

Энэхүү зөвлөмжийг Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.5 дахь хэсэгт заасны дагуу төлөвлөгөө гарган хэрэгжүүлж, биелэлтийг 2025 оны 06 дугаар сарын 15-ны дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчил нь бидний тогтоосон материаллаг түвшингээс бага байгаа тул "**Өөрчлөлтгүй**" дүгнэлт өглөө.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

### Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

| Алдааны товч утга | Нийт алдаа | | Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан | | Буруу тусган илэрхийлсэн | | Үнэлгээ | | | | Зөвлөмж | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | Залруулсан | | Залруу-лаагүй | | | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| | | | | | | | | | | | | |
| | | | | | | | | | | | | |
| **Дүн** | | | | | | | | | | | | |

### Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үнэлгээ | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | | Хариуцлага тооцуулах албан шаардлага | | Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Албан тушаалтны тоо | Тоо | Дүн |
| Гүйцэтгэлийн үнэлгээнд хамрагддаг ТҮБД-ийн эрхлэгч,багш,туслах багшид эрхлэгчийн тушаалаар мөнгөн урамшуулал олгосон | 1 | 4378.1 | 1 | 4378.1 | | | | | | | | |
| Үдийн хоолны зардлаас зориулалт бусаар торгууль төлсөн | 1 | 1700.0 | 1 | 1700.0 | | | | | | | | |
| Анхны өртгөө элэгдлээрээ нөхсөн 0 үлдэгдэлтэй байгаа 226 нэр төрлийн 1696 ширхэг 287,694,427.60 төгрөгийн хөрөнгийг дахин үнэлж ашиглалтын хугацааг сунгах | 1 | | | | | | 1 | | | | | |
| **Дүн** | | **6078.1** | | **6078.1** | | | **1** | | | | | |

**АУДИТЫН ТАЙЛАНГ:**

**ХЯНАСАН:**

АХЛАХ АУДИТОР Ц.ОЮУНСУВД

АУДИТЫН МЕНЕЖЕР: Х.БОЛДБААТАР

ДАРГА,ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Д.БАТ-УНДРАА

Огноо: 2025-02-22

**БОЛОВСРУУЛСАН:**

"ХААН СОЁМО АУДИТ" ХХК ГЭРЭЭТ АУДИТОР Б.ЦЭРЭНДЭЖИД

Огноо: 2025-02-22